



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**ЧОЙРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ
БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР А.АЮУШ ТАНАА**

2014.03.26 № 2/10 ЧАГ-САГ/2014/45/СТГА-ТШЗ

Төсвийн орлого болгох тухай

Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын эзэмшилд буй 2 автомашины нэг болох Соната-6 маркийн автомашиныг ЭЗХЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга нь ашигладаг, тус байгууллагын 2013 оны батлагдсан 1,095.0 мянган төгрөгийн шатахууны зардлаас 1,035.5 мянган төгрөгийн шатахууныг авч ашигласан байна.

Энэ нь Монгол улсын “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.. гэсэн, Засгийн газрын 2007 оны 349 тоот тогтоолын 1 дэх хавсралтад батлагдсан “Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 “ аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2.1.1-ийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгууллагын төсвийг зүй бусаар зарцуулсан 1,035.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж Төрийн сан дахь УАГ-ын 900000601 тоот дансанд 2014 оны 4 дүгээр сарын 10-ны дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг Үндэсний аудитын газарт 2014 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны ерөнхий менежер А.Аюуш, нягтлан бодогч Д.Хишигбаяр нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
Үндэсний аудитын газрын
аудитор
 Ш.Отгонбаяр
УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:
Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийн
Захирагчийн ажлын албаны ерөнхий менежер
 А.Аюуш
Нягтлан бодогч
 Д.Хишигбаяр